



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: ШУТИС, Геологи, уул уурхайн сургууль

Хөтөлбөрийн нэр: Ашигт малтмалын эрэл, хайгуул

Индекс: D053209

Шинжээчийн баг:

Ахлагч: Д.Сарангэрэл, МУИС, ШУС-ийн Байгалийн Ухааны
Салбарын Химийн тэнхимийн профессор, доктор

Гишүүд: Д.Одгэрэл, Геологийн хүрээлэнгийн захирал,
доктор
Б.Баатарцогт, Цөмийн энергийн комиссын ажлын
албаны тамгын газрын дарга, доктор

Он сар өдөр: 2023.10.12

Агуулга

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Товчилсон үгийн тайлбар

ШУТИС	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль
ГУУС	Геологи, уул уурхайн сургууль
АМЭХ	Ашигт малтмалын эрэл хайгуул
ГГС	Геологи, гидрогеологийн салбар
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
ЭЕШ	Элсэлтийн ерөнхий шалгалт
ДЧБ	Дотоод чанарын баталгаажуулалт
ХЧБ	Хөндлөнгийн чанарын баталгаажуулалт
ЧХШҮА	Чанарын хяналт, шинжилгээ, үнэлгээний алба
ХДХ	Хөтөлбөрийн дэд хороо
АМЭХ	Ашигт малтмал эрэл хайгуул

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	ШУТИС, Геологи, уул уурхайн сургууль	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	Ашигт малтмалын эрэл, хайгуул	
Индекс	D053209	
Шинжээчид	Д.Сарангэрэл Д.Одгэрэл Б.Баатарцогт	Монгол улсын их сургуулийн Шинжлэх ухааны сургуулийн доктор, дэд профессор Геологийн хүрээлэнгийн захирал, доктор Цөмийн энергийн комиссын ажлын албаны тамгын газрын дарга, доктор
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Соёлмаа	БМИҮЗ-ий магадлан итгэмжлэл, статистик хариуцсан мэргэжилтэн
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2023.10.03	Сургуулийн орчинтой танилцах
	2023.10.03-04	Сургуулийн бэлтгэсэн материал, илрэл нотолгоотой шинжээчид танилцах
	2023.10.04	Оюутнуудын төлөөлөлтэй уулзах
	2023.10.03	Төгсөгчдийн төлөөлөлтэй уулзах /цахимаар/
	2023.10.03	Ажил олгогчийн төлөөлөлтэй уулзах /цахимаар/
	2023.10.04	Багш нартай уулзах
	2023.10.03-04	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах
	2023.10.04	Шинжээчдийн баг магадлан итгэмжлэлийн урьдчилсан дүгнэлтийг байгууллагад мэдэгдэнэ.
Шалгуур шаардлага /журам/	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлага”	

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Ашигт малтмалын эрэл хайгуул хөтөлбөр нь D053209 индекстэй, бакалаврын түвшний хөтөлбөр юм. Монгол улсын аж үйлдвэр, геологи, уул уурхайн салбар, эрдэм шинжилгээний байгууллагад ажиллах ашигт малтмалын эрэл хайгуул мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх хэрэгцээ шаардлагыг үндэслэн ШУТИС-ийн АМЭХ бакалаврын зэргийн хөтөлбөрийг БШУЯ-ны сайдын 2022 оны 5-р сарын 9-ны өдрийн А/160 тушаалаар баталсан. Уг хөтөлбөрийг 1970 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн түүхтэй байна. Энэ хугацаанд нийт 309 төгсөгч АМЭХ бакалавр зэргийн хөтөлбөрөөр амжилттай төгссөн байна.

Хөтөлбөрийн үндсэн багш нар 7 профессор багш ажилладаг. Магадлан итгэмжлэлийн тайланг бичихдээ бүлэг тус бүрээр хариуцан ажиллажээ.

1970-2001 онуудад ПДС-ийн геологийн хөтөлбөрт “Ашигт малтмалын хайгуулын геологич” мэргэжил харьяалагдаж байгаад 2002 онд АМЭХ хөтөлбөр анх нээгдсэн. 2014 онд геологи хөтөлбөртэй нэгдсэний дараа 2018 онд АМЭХ-ын трак хөтөлбөрийг геологи хөтөлбөр дотор нээсэн. 2022 оноос зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн бие даасан АМЭХ хөтөлбөрийг дахин нээж хэрэгжүүлж байна. Өнөөдөр энэ хөтөлбөрөөр 1-2-р түвшний 16 оюутан (1-р түвшинд 10, 2-р түвшинд 6) суралцаж байна.

Хөтөлбөрийн нэр, индекс	Мэргэшиж буй салбар	Хөтөлбөрийн багийн ахлагч	Сургалтын хэлбэр	Хугацаа	Кредит
Ашигт малтмалын эрэл, хайгуул	Геологи	Б.Алтанзул	өдөр	4	130

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Илрэл нотолгоо:

- Хэрэгцээ шаардлагыг STEEP (нийгэм ба хүн амзүй, технологи, эдийн засаг, хүрээлэн буй орчин ба байгаль, улс төр ба хууль) шинжилгээнд суурилан гаргаж, боломж, сорилт, ажлын ирээдүйг төлөвлөж, шинэ өрсөлдөх чадварыг мэдлэг, чадвар, хандлагаар нь томъёолсон байна.
- Хөдөлмөрийн зах зээл, эрэлттэй мэргэжлийн судалгаанд геологич мэргэжил орсон
- Ашигт малтмалын эрэл, хайгуул хөтөлбөрийн төгсөгчдийн ажил эрхлэлт 85-90% орчим байна
- ШУТИС-ийн хөтөлбөрийн ерөнхий хорооны хурлын шийдвэр (2023.06.12, 08): хичээлийн хөтөлбөрийг нэг стандартад оруулах, агуулгыг дахин нягтлах, холбогдох мэдээллийг шинэчлэх, суралцахуйн үр дүнгийн хамаарлыг тодорхойлох зэрэг асуудлыг хэлэлцэн дэмжсэн байна.
- Ашигт малтмал эрэл, хайгуул хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө
- 2022.11.23-ны өдөр “Геологийн салбарын сургалт, судалгаа, хамтын ажиллагаа, хөгжлийн чиг хандлага” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулж, салбарын нийт 100 орчим мэргэжилтнүүд цугларч салбарын үйлдвэрлэл, судалгаа, цаашдын хамтын ажиллагааны нөөц боломжийн талаар зөвлөлдсөн байна. Оролцогсод хөтөлбөрийн хөгжүүлэлтэд оруулах хувь нэмэр, тулгарч буй асуудлаа 17 хүн бичгээр санал өгсөн байна.
- Сургалтын төлөвлөгөөний олон улсын болон дотоодын харьцуулсан судалгааг энэ чиглэлийн хичээл бүрээр дэлгэрэнгүй хийсэн судалгаа байна.
- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн хувь 90%-аас дээш байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- STEEP шинжилгээний үр дүнд зөөлөн ур чадваруудыг орхигдуулсан, мэргэжлийн дадал чадвар олгоход түлхүү анхаарах шаардлагатай болохыг дүгнэж сургалтын хөтөлбөрийн цаашдын хөгжилд тусгах шийдвэр гаргадаг.

Зөвлөмж:

- 2023 онд шинээр баталсан сургалтын төлөвлөгөөг харьцуулсан судалгаанд тулгуурлан өөрчилсөн баримт нотолгоог дэлгэрэнгүй, харагдахуйц байдлаар хийж хэвших нь зүйтэй.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн зорилго, зорилтыг ШУТИС-ийн эрхэм зорилгод нийцүүлэн хувь хүний хөгжүүлэгч, зан төлөвшил, сайн хамтрагч, санаачлагч хэрэгжүүлэгч мэргэжилтнийг бэлтгэх гэж тодорхойлсон байна.
- Хөтөлбөрийн хувьд 1-р түвшний хавар мэргэжлийн суурь хичээл, 2-р түвшнээс эхлэн мэргэжлийн хичээлийг үзэж эхлэхээр сургалтын үйл ажиллагааг төлөвлөсөн.
- 4 үйлдвэрлэлийн дадлагатай.
- 2022-2023 оны хичээлийн жилийн салбарын мэргэжил сурталчлах ажлын төлөвлөгөө: ЕБС-ийн сурагчид, олон нийтэд зориулсан мэргэжил сурталчлах, танилцуулга, шторк хийх, салбарын судлаач, мэргэжилтнүүдийг алдаршуулах, ярилцлага хийх зэрэг үйл ажиллагааг төлөвлөсөн байна.
- Хөтөлбөрийн танилцуулгыг шинэчлэн боловсруулсан.
- Ажил олгогчдын уулзалтыг сүүлийн 3 жилд 1-2 удаа зохион байгуулсан.
- ЮНЕСКО-ийн боловсролын 4 тулгуурт зарчимд суурилан ажлын байранд гарах мэргэжилтний ур чадварт суурилан хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг боловсруулжээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Ажил олгогчидтой уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулан, уулзалтаас гарсан санал зөвлөмжийг сургалтын хөтөлбөрийн сайжруулалт, үйл ажиллагаандаа тусган ажиллахыг эрмэлздэг.
- Ажил олгогчидтой хийсэн асуулга ярилцлагаас харвал хөтөлбөрийн багш нар бүх түвшинд хамтран ажилладаг байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн зорилгын өөрчлөлтийн талаар олон нийтэд мэдээлсэн талаар баримт материал олдоогүй тул салбарын веб хуудсаар дамжуулан нийтэд түгээхэд анхаарах

1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийг 2002, 2014, 2018, 2023 онуудад шинэчлэн сайжруулалт хийгдсэн байна. 2014 онд хөтөлбөрийг нэгтгэсэн учраас бүрэн хэмжээний өөрчлөлт хийгдсэн.
- Сургалтын төлөвлөгөөний 130 БЦ-ийн 15.3% нь сонгон судлах хичээл байна.
- 2002, 2018, 2023 оны сургалтын төлөвлөгөө
 - 2002 оны АМЭХ хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд суурь ухааны 44, мэргэжлийн суурийн 46, мэргэшүүлэх 30, дадлага 4, дипломын төсөл 5 БЦ нийт 130 БЦ байсан байна.
 - 2018 оны Геологи хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд ашигт малтмалын эрэл, хайгуул мэргэжлийн чиглэл орсон. Бүтцийг авч үзвэл ерөнхий суурийн 39, мэргэжлийн суурийн 37, мэргэшүүлэх 43, дадлага 6, дипломын ажил, төсөл, шалгалт 5 БЦ нийт 130 БЦ байсан байна.
 - 2023 оны АМЭХ хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд ерөнхий суурийн 34, мэргэжлийн суурийн 32, мэргэшүүлэх хичээлийн 44 БЦ нийт 130 БЦ байна. Үүнээс дадлага 6, төсөлт ажил 3, дипломын ажил, төсөл 5 БЦ буюу нийт ур чадвар олгохтой холбоотой багц цаг 14 БЦ байна. Сургалт үйлдвэрлэлийн дадлага 3 БЦ хичээлийг оюутан сонгон судлах боломжтой байна.
- 2019 онд CDIO шаардлагад нийцүүлэн бүх хичээлийн хөтөлбөрийг сайжруулалт хийсэн.
- ШУТИС-ийн хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааг зохицуулах журмыг шинэчлэн батлах тухай ШУТИС-ийн захирлын 2022.05.24-ний А/173 тоот тушаал
- ГУУС-ын хөтөлбөрийн дэд хороогоор 2022-2023 онд хэлэлцүүлсэн асуудлын тайлан:
 - 2022.09.09, 09.16: хөтөлбөрийн дэд хорооны хичээлийн жилийн төлөвлөгөөнд АМЭХ хөтөлбөрийн Сургалтын төлөвлөгөөний өөрчлөлт сайжруулалттай холбоотой асуудлыг хэлэлцүүлэхээр төлөвлөсөн
- МУИС-ийн геологи хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө, Тохоку их сургуулийн гео хүрээлэн буй орчин судлал салбарын хичээлийн жагсаалт
- Бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам, ШУТИС-ийн ректорын 2014.06.13-ны А/105, 2015.09.01-ний А/188 тоот тушаал
- Сургалтын батлагдсан төлөвлөгөө
 - 2018 онд ШУТИС-ийн ЭЗ-ийн хурлаар батлагдсан (Хөтөлбөрийн бүтэц: Ерөнхий суурь 40 (34+6), Мэргэжлийн суурь хичээл 38 (27+11), мэргэжлийн хичээл 52 (39+13), Дадлага 6, дипломын ажил, төсөл, шалгалт 5 нийт 130 БЦ)

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын төлөвлөгөөнд 6 багц цагийн дадлага, 5 багц цагийн дипломын төсөл тусгаж, дүрэм журамд заасны дагуу заавал, сонгон суралцах хичээлийн агуулгыг тодорхой залгамж холбоотойгоор боловсруулсан байна.
- Хичээлийн хөтөлбөрүүд нь багц цагийн хуваарилалт, орох багш нар, сэдэв, үнэлгээ, арга зүй, ном зүй зэрэг агуулгатай, бүгд нэг загвараар хийгдсэн байна.

- Сургалтын үйл ажиллагааг явуулахдаа тонгоруу, асуудал шийдвэрлэх, кейс судалгаа, даалгаварт суурилсан сургалтын арга зүйг хэрэглэдэг.
- Харьцуулан судалж буй сургалтын хөтөлбөрийн бүтэц, хичээлийн давхцалын хувь зэргийг дэлгэрэнгүй гаргаж, олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн хөтөлбөр мөн эсэхийг баримтаар нотлон харуулсан байна.
- АМЭХ хөтөлбөр нь геологи хөтөлбөртэй ерөнхий суурь хичээлийн ялгаа 3.2%, мэргэжлийн суурь хичээлийн ялгаа 30.0%, мэргэшүүлэх хичээлийн давхцал 19.9%, буюу 80.1% зөрүүтэй байна.

Анхаарах асуудал:

- Сургалтын төлөвлөгөөнд тухайн хөтөлбөрөөр суралцагчдын хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, ажил олгогчдын шаардлагад нийцсэн мэдлэг, ур чадвартай болгоход нэн шаардлагатай англи хэл, хятад хэл, геологи, эдийн засаг, компьютер, мэдээллийн технологийн хичээлийг судлах боломжийг нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай.
- Ялангуяа нийтлэг хэрэглэгддэг, тухайн салбарын программ хангамжийг хэрэглэхтэй холбоотой агуулгыг холбогдох хичээлийн төлөвлөгөөнд оруулах хүсэлтийг суралцагч, төгсөгчид дамжуулж байна.
- Үйлдвэрлэлийн дадлагын бодит хэрэгжүүлэх хугацааг багасгаж орсон тохиолдол гарсан тул төлөвлөгөөнд заасны дагуу дадлагын хичээлийг ордог байхад анхаарах нь зүйтэй.

Зөвлөмж:

- Төгсөгч, ажил олгогчдын ярилцлагын үеэр гарсан англи хэл, хятад хэл, геологи, иргэний боловсрол, хөдөлмөр аюулгүй байдал, компьютер, мэдээллийн технологийн хичээлийн агуулгыг нэмэгдүүлэх, сонгон судлах боломжийг бий болгох, хөтөлбөрийн уян хатан байдлыг нэмэгдүүлэхэд цаашид анхаарах нь зүйтэй.
- Суралцагчид, төгсөгчид сургалтын хөтөлбөрт мэргэжлийн хичээлийн эзлэх хувийг ихэсгэх, ерөнхий суурийн сонгон судлах хичээлийн агуулгыг сайжруулах хүсэлтийг хүргүүлж байна.
- Ажил олгогчдын саналын дагуу үйлдвэрлэлийн дадлагын хугацааг уртасгах, үр өгөөжийг нэмэгдүүлэхэд тодорхой арга хэмжээ авах зайлшгүй шаардлагатай.
- Геологи хөтөлбөрөөр хос бакалаврын зэрэг авах, хавсарга хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлбэл хөтөлбөрийн уян хатан байдал, төгсөгчдийн хөрвөх чадвар сайжрахад эерэг нөлөө үзүүлэх боломжтой.

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Илрэл нотолгоо:

- Залгамж холбоо бүхий сургалтын төлөвлөгөө боловсруулсан.
- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүн (ABCD)-г гаргахдаа Юнескогийн боловсролын 4 тулгуурт зарчимд нийцүүлсэн байна.
- PIVOT анализ (СҮД-г хичээлийн төрөл, түвшнээр нь тус бүрд нь боловсруулсан), хөтөлбөрийн суралцахуйн үр дүнгийн матриц (3 түвшинтэй)-ыг боловсруулсан.
- Ашигт малтмалын эрэл хайгуул хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө, 2001 он
- Мэргэжлийн чиглэл индекс шинэчлэн батлах тухай, 2014.03.14, БШУС-ын А/78 тоот тушаал: Геологи хөтөлбөр, D053203
- Ашигт малтмал, газрын тосны газар (2016.12.02, 1/2203), МУ-ын уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд (2017.05.12, 01/1100), Мэргэжлийн хяналтын газар (2016.12.09, 02-10/3855), Алтан Рио Монголиа ХХК (2016.12.02), Терра Сийд ХХК (2016.11.25, 44/16), Монгол меатлл консалтинг ХХК (2016.11.25, 44/16), Брейвхарт ресорсиз ХХК (2016.12.01, 15/2016), ГУУС-ын захиргаа (2017.03.22, 2018.05.07)-ны хурлаар ашигт малтмал эрэл, хайгуул хөтөлбөрөөр мэргэжлийн чиглэл нээх хүсэлтийг холбогдох газар хүргүүлсэн баримтууд
- Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлах тухай (БШУ-ы сайдын 2022.05.09-ний А/160 тоот тушаал) 053209 ашигт малтмалын эрэл, хайгуул хөтөлбөр
- ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2014.07.02-ны хурлаар батламжилсан “Геологи” хөтөлбөрийн шинэчилсэн сургалтын төлөвлөгөө, D053203
- ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2016.06.27-ны хурлаар батламжилсан “Геологи” хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө, D053203
- ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2018.06.28-ны хурлаар батламжилсан “Геологи” хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө, D053203, энэ төлөвлөгөөнд ашигт малтмал эрэл, хайгуул мэргэжлийн чиглэлийг оруулж өгсөн
- Мэргэжлийн чиглэл индекс шинэчлэн батлах тухай, 2022.05.09, БШУС-ын А/160 тоот тушаал: Геологи хөтөлбөр, D053204, Ашигт малтмалын эрэл, хайгуул, D053209
- ШУТИС-ийн сургалтын ажил эрхлэх тусгай зөвшөөрөл, 2020.03.02, мэргэжлийн чиглэл Геологи хөтөлбөр, D053203
- ШУТИС-ийн улсын бүртгэлийн гэрчилгээ, 2001.08.22
- БСШУС-ын сайдын 2017.06.29-ний А/52 тоот тушаал: Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлах тухай тушаалын хавсралтад өөрчлөлт оруулах тухай: 0532 Дэлхий судлал ажил мэргэжил судлал дотор 05320302 индекстэй ашигт малтмалын эрэл, хайгуул (Mineral exploration) хөтөлбөрийг оруулсан байна.

- Үйлдвэрлэлийн дадлага хийх албан бичиг, хичээлийн хөтөлбөр, дадлагын удирдамж, зарим оюутны дадлагын тайлан
- Сургалтын нэгдсэн хуанлийг улирал бүрээр гаргаж мөрддөг.
- Үйлдвэрийн дадлагын албан бичиг, хамтын ажиллагааны гэрээ, үйлдвэрлэлийн дадлагын гэрээ, тайлангууд
- Оюутны дадлага, төгсөлтийн ажил гүйцэтгэх, төгсөлтийн улсын шалгалтын удирдамж, 2021
- Хөтөлбөрийн дэд хороо хичээлийн жил бүрээр төлөвлөгөө гаргаж тайлагнадаг
- Хөтөлбөрийн баримт бичиг (ерөнхий танилцуулга, сургалтын зорилго, зорилт, сургалтын үр дүн, сургалтын арга зүй, сургалтын орчин, элсэгчдэд тавигдах шаардлага, багшлах бүрэлдэхүүний судалгаа, хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт, харилцаа хамтын ажиллагаа) боловсруулж ШУТИС-ийн захирал баталгаажуулсан байна.
- Хөтөлбөр дэх хичээлийн онцлогоос хамааран лекц, семинар, лаборатори хосолсон хэлбэрээр сургалтын үйл ажиллагаа явагддаг, үйлдвэрлэлийн дадлага 6 кредитээр, төсөлт ажил, судалгааны ажил 5 кредитээр судалдаг.
- АМЭХ хөтөлбөрийг геологи хөтөлбөртэй харьцуулсан судалгаа хийсэн байна. Мөн МУИС-ийн Геологи хөтөлбөр, Малайзийн Куртиний их сургууль, Австралийн Шинэ Английн их сургууль, Эксетерийн их сургуулийн адил төстэй хөтөлбөртэй харьцуулсан судалгаа хийж, хөтөлбөрийн агуулгыг боловсруулсан байна. Хөтөлбөр дэх мэргэжлийн хичээлийн давхцал 48-56%-тай байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага

- Хөтөлбөрийн дэд хороо нь хичээлийн жил бүрээр үйл ажиллагаагаа төлөвлөж, тайлагнадаг.
- Үр дүнд суурилсан боловсролын стандарт арга зүйг 2014 оноос хэрэгжүүлэн бүх багш нар сургалтад хэдийнээ нэвтрүүлсэн байна.

Зөвлөмж:

- Оюутнууд, багш, төгсөгчид, ажил олгогчидтой хийсэн уулзалт болон АМЭХ бакалаврын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланг үндэслэн үйлдвэрлэлийн дадлагын хугацааг уртасгах, чанаржуулахад цаашид анхаарч ажиллахыг зөвлөж байна.
- Бүх оролцогч талууд үйлдвэрлэлийн дадлага, хээрийн дадлагыг чанаржуулах, үр өгөөжийг нэмэгдүүлэх, хүрэх үр дүнг тодорхой болгоход анхаарах хэрэгтэй гэж үзэж байна. Үйлдвэрлэлийн дадлагын хугацааг бодитоор нь дүрэм журамд заасны дагуу хэрэгжүүлэх шаардлагатай.
- Бүх оролцогч талууд оюутнуудад орчин үеийн мэргэжлийн программ хангамж дээр бие даан ажиллуулах боломж нөхцөлийг бий болгохыг зөвлөж байна.

2.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- Мэргэжлийн дадлага хийх журам, Ректорын 2011.06.24-ний А/43 тоот тушаалын хавсралт
- Хичээлийн шинэчилсэн хөтөлбөрт хичээл заах багшийн мэдээлэл, улирал, багц цаг, товч тодорхойлолт, өмнөх холбоо, багц цагийн задаргаа, холбоо барих хаяг, хичээлийн суралцахуйн үр дүн, түүний хөтөлбөрийн суралцахуйн үр дүнтэй холбогдох хамаарал, сургалт явуулах хэлбэр, ашиглах материал, долоо хоног бүрээр сэдэв, сэдвийн СҮД, хичээлийн СҮД-тэй хамаарал, хичээлийн хэлбэр, заах арга, суралцах арга ажиллагаа, урьдчилан уншиж ирэх материал, сурагчаас авах санал асуулга, үнэлгээний рубрик, үнэлгээний хэлбэр, давтамж, гүйцэтгэлийн шалгуур, үнэлгээний хувь зэргийг багтаасан байна.
- СДИО сургалтын арга зүйг хэрэгжүүлэх 6 түвшний гарын авлага (багш нарын хувь хүний болон багшлахуйн чадварыг дээшлүүлэх, ажлын орчин бүрдүүлэх, хосолсон болон идэвхтэй сургалт явуулах, нийлмэл сургалтын хөтөлбөр, хичээлийн хөтөлбөр боловсруулах, сургалтын явцын үнэлгээг шинэчлэх, сургалтын хөтөлбөрт нэгдсэн үнэлгээ хийх, хөтөлбөрийн боловсролын зорилго, зорилтууд, суралцахуйн үр дүнг тодорхойлох зэрэг)-ыг сургалтад хэрэглэдэг.
- Явцын болон улирлын шалгалтын материал боловсруулах удирдамж, 2023

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- 2023 оноос эхлэн Явцын болон улирлын шалгалтын материал боловсруулах удирдамжийг боловсруулж хэрэгжүүлж эхэлж байна.
- Сургалтын системд багш улирлын эхэнд хичээлийн онооны хуваарилалтаа урьдчилан тохируулах боломжтой.
- Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, үр дүнд суурилсан, идэвхтэй сургалтын арга зүйг дэмжсэн, багшийн заах арга зүйг хөгжүүлэх тогтсон үйл ажиллагаатай.
- Геологи, АМЭХ хөтөлбөрөөр төгссөн төгсөгчид хөрвөх чадвар сайтай, практик чадвартай байдгийг онцолж байна.

Зөвлөмж:

- Багш нарын заах арга зүй харилцан адилгүй учраас идэвхтэй сургалтын арга зүйг үр өгөөжтэй хэрэглэх, суралцагчийн мэдлэг, ур чадвараа танил бус орчин нөхцөлд хэрэглэх чадвартай болгоход анхаарахыг зөвлөж байна.
- Зарим хичээлийн, тухайлбал, ерөнхий хими хичээлийн агуулга өөр хичээлтэй давхардах, хичээлийг чанаргүй орох зэрэг асуудал гарч байгаа тул оюутны сэтгэл ханамжийн үнэлгээг авч, зохих арга хэмжээ авах нь зүйтэй.

2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- UNIMIS системээс харахад Блумын таксономын 3-4 түвшин бүрээр хүндрэлийн зэргийг ялган шалгалтын материал боловсруулдаг, багшийн явцын болон шалгалтын үнэлгээнд задаргаагаараа гарч ирэх ба тус бүрээр нь үнэлдэг. Явцын үнэлгээг CDIO 12 стандарт шалгуурын дагуу үнэлдэг.
- 2014.04.14, А64 ШУТИС-ийн бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам: Оюутны мэдлэгийн үнэлгээ
- Улирлын шалгалт, төгсөлтийн үйл ажиллагааг зохион байгуулах удирдамж, 2023.05.01,
- Хичээлийн хавтас бүрд үнэлэх зарчим, үнэлгээний даалгавар, дүнгийн шинжилгээ хавсаргасан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Явцын үнэлгээг үр дүнд суурилсан сургалтын 12 шалгуурын дагуу үнэлдэг бөгөөд Улирлын шалгалт, төгсөлтийн үйл ажиллагааг зохион байгуулах удирдамжийг 2023.05.01-ээс эхлэн мөрдөж байна.
- Суралцагчид, төгсөгчид мэргэжлийн хичээлийн суралцагчийн үнэлгээ маш бодитой, шударга байдгийг онцолж байна.

Анхаарах зүйл:

- Мэргэшүүлэх хичээлийн үнэлгээ бодитой хэдий ч бусад хичээлүүдийн үнэлгээний зарчим, үнэлгээ нь бодитой эсэхэд суралцагчид эргэлзэж байна.

Зөвлөмж:

- Суралцагчид шалгалт өгсний дараа эргэх холбоог хэрхэн өгдөг талаар баримт нотолгоо олдоогүй учраас суралцагчид алдаан дээрээ суралцах, алдаатай ойлголтоо засаж залруулах боломжийг олгох нь зүйтэй.

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Илрэл нотолгоо:

- Дээж бэлтгэл, микроскоп судалгаа, харьцуулах судалгаа, нарийвчилсан багажит шинжилгээний нийт 8 лабораторитой. Үүнээс 2 лаборатори сургалтын зориулалттай, үлдсэн 8 лаборатори судалгааны зориулалттай байна.
- Сургалтын программ хангамж: ArcGIS, ArcView, Micro Mine, Map info, Statistica, opGAS, LeapFrog
- Горхи Тэрэлжид үйлдвэрлэлийн, танилцах дадлагын полигонтой.
- Сургалт явуулж буй хичээлийн анги танхим, лаборатори болон багшийн ажиллах орчин нь стандартын шаардлага, эрүүл ахуй аюулгүй байдлыг хангасан байна.
- Бодисын шинжилгээний, дээж шлиф бэлтгэлийн, минералог хүдэр судлалын, петрограф, минераграфын, байгалийн нөөц судлалын лабораториуд байгуулж үйл ажиллагаа явуулж байна.
- Ашигт малтмал, эрэл хайгуул, геологийн кабинетыг тохижуулж сургалтад ашиглаж байна.
- Багш ажилчдын өрөө байрны багтаамж хүрэлцээ хангалттай.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Олон улсын төсөл хөтөлбөрийн хүрээнд орчин үеийн лабораторийн тоног төхөөрөмж бүхий судалгаа, шинжилгээний лабораторийг байгуулсан байна.
- Төгсөгчидтэй эргэх холбоо сайн ба төгсөгчид хичээлийн анги, танхим, кабинет зэргийг тохижуулж орчин нөхцөлийн сайжруулж өгдөг.

Анхаарах асуудал:

- Хичээлийн анги, танхимын сандал, ширээ, шал хуучирсан таатай орчин нөхцөл төдийлөн бүрдээгүй байна. Зарим лекцийн анги танхимын проекторыг солих, микрофон байрлуулах, стандартын ширээ сандалтай болгох, агааржуулалт байрлуулах шаардлагатай.
- Сургалтын багаж төхөөрөмжийн үзүүлэлт, хүртээмжийг нэмэгдүүлэх, оюутан гардан туршилт хийх бололцоогоор хангалт төдийлөн сайн биш.
- Ариун цэврийн өрөөний тохижилт, сангийн асуудлыг нэн даруй засаж багш, суралцагчийн тав тухыг хангах шаардлагатай.

- Багш нарын өрөө, ажлын байрны хүрэлцээ сайн хэдий ч тохижилт хангалттай биш байдаг.
- Кредит тооцох, шилжүүлэх асуудлыг журмаар зохицуулсан байдаг ч хэрэгжүүлдэггүй.

Зөвлөмж:

- Судалгаа, шинжилгээний лабораторийг ашиглан судалгааны төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, улсын болон хувийн хөрөнгөөр гүйцэтгэх ажлыг гүйцэтгэн нэмэлт орлого төвлөрүүлэх боломжтой харагдаж байна.
- Зарим анги танхим, багш нарын өрөөний тохижилтыг сайжруулж таатай орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.
- Зураглалын зэрэг хичээл ордог анги танхимыг мэргэжлийн тохижилттой болгох, компьютерын лабораторийн хүртээмж, ашиглалт, даацыг нэмэгдүүлэх, хичээлийн бус цагаар ашиглах боломжийг бий болгоход анхаарч ажиллахыг зөвлөж байна.
- Сургуулийн орчинд бие даан суралцах орчин нөхцөл хязгаарлагдмал, хүртээмж багатай байдаг тул хөтөлбөрийн оюутнуудад мэргэжлийн анги танхимыг хүртээмжтэй болгох хэрэгтэй юм.
- Лабораторийн урсгал зардлыг багш нарын судалгааны төслөөс бус сургуулийн төсвөөс жил бүр шийдэж өгдөг байх нь сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулахад тустай.

3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Бодисын шинжилгээний, дээж шлиф бэлтгэлийн, минералоги хүдэр судлалын, петрографи, минераграфийн, байгалийн нөөц судлалын лабораториуд байгуулж үйл ажиллагаа явуулж байна.
- Ашигт малтмал, эрэл хайгуул, геологийн кабинетыг тохижуулж сургалтад ашиглаж байна.
- Сургалтад ашиглах мэргэжлийн 10 төрлийн орчин үеийн программ хангамжийн эрхийг зөвшөөрөлтэйгөөр ашиглаж байна. Программ хангамжийг тухайн хичээлийг заадаг багш өөрийн хичээлийн цагт тодорхой семинар хэлбэрээр зааж сургадаг ба компьютерын лабораторийг тухайн цагт ашигладаг байна.
- Сургалтын дадлагын полигон, геологи эрдэс баялгийн музейн байгуулж ажиллуулж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Анхаарах асуудал:

- Горхи Тэрэлжид байрлах дадлагын полигоныг завсарлаж орчин нөхцөлийг сайжруулахад сургуулийн удирдлагын зүгээс анхаарах шаардлагатай.

Зөвлөмж:

- Геологи, хайгуулын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа орчин үеийн программ хангамжийг зааж сургах тал дээр илүү анхаарч ажиллах хэрэгтэй байгаа талаар төгсөгчид болон ажил олгогчдоос санал гаргаж байна.
- Петрографийн лабораторийн микроскопын хүрэлцээг нэмэгдүүлж оюутан дадлага, практикийн хичээлийн биечлэн гүйцэтгэх боломжийг бүрдүүлэхэд анхаарах хэрэгтэй байна.

3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Салбарын номын сантай: Салбарын багш нар ном сурах бичиг, гарын авлага, орчуулгын ном сурах бичиг хэвлэн нийтлүүлдэг. Энэ нь монгол хэл дээр бичигдсэн ном сурах бичгийн хангамжийг нэмэгдүүлэх тустай.
- ШУТИС-ийн төвлөрсөн номын сангаас гадна оюутны мэргэжлийн ном сурах бичиг, сэтгүүлээр баяжуулсан номын сан ажиллуулж байна. Үүнд, монгол, англи, орос хэлээр бичигдсэн 3000 орчим ном сурах бичиг байна. Мөн геологийн мэргэжлийн 7 сэтгүүлийн дугаар байна.
- Сүүлийн 7 жилийн хугацаанд мэргэжлийн 25 ном сурах бичгийг тус сургуулийн багш нар зохион хэвлүүлжээ.
- Төвлөрсөн номын сан нь оюутан судлаачдыг тав тухтай үйлчлүүлэхэд анхаарсан таатай орчныг бүрдүүлснээс гадна цахим номын сан, хайлтын систем, оюутан суралцах цахим орчныг бүрдүүлжээ.
- EBSCO олон улсын мэдээллийн инженерийн багц, Springer, Research for Life эрдэм шинжилгээний өгүүллийг сургуулийн интернэт орчноос татаж унших боломжтой.
- 2022 оны 03-р сараас эхлэн олон улсын лицензтэй хуулалтыг шалгах программыг нэвтрүүлсэн.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Олон улсад нэвтэрсэн цахим программ хангамжийг ашиглан гадаадын судалгааны өгүүлэл, ном сурах бичгийг хайж, ашиглах боломж бүрдсэн байна.
- Оюутнууд өөрийн нөүтбүкээ авчран интернэтийн суралцах боломжийг олгосон байна.
- Оюутан уншлагын танхимд зөвхөн өдрийн цагаар төдийгүй 24 цагийн туршид үйлчлүүлэх боломж, нөхцөлийг бүрдүүлжээ.

Анхаарах асуудал:

- Суралцагчдад зарим мэргэжлийн хичээлийн ном, сурах бичиг цөөн тоотой, хүрэлцээ муу байдаг.
- Монгол хэл дээрх ном сурах бичгийн хүртээмж хангалт муу, бүтээл хийх, ном хэвлүүлэх санхүүжилт багшид байдаггүй. Энэ нь багшийн үйлдвэрлэлийн байгууллагатай хамтран

ажиллах, судалгаа хийх боломжийг хязгаарлаж, сургалтын материал бэлтгэхэд цаг их зарцуулахад хүргэж байна.

Зөвлөмж:

- Ном сурах бичгийн тоог нэмэгдүүлж оюутан сурагчдад илүү хүртээмжтэй болгох шаардлагатай байна.
- 1-р түвшний оюутнууд намар элсэж орсны дараа шууд үнэмлэхтэй болох, өөрөөр хэлбэл үнэмлэх олголтыг хурдан хийх, номын сангийн үйлчилгээ авах шаардлагатай байна.

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчныг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Илрэл нотолгоо:

- Вэбсайтаас сургалтын үйл ажиллагааг удирдан зохион байгуулдаг.
- Геологи хөтөлбөрийг CDIO стандартад нийцүүлэхтэй холбоотой хичээлийн жилд хийх ажлын төлөвлөгөө гарган ажилладаг
- Хичээлийн төлөвлөгөөг стандартын дагуу боловсруулж үнэлгээг CDIO үнэлгээний дагуу хичээл тус бүрээр заадаг, хэрэглэдэг, үнэлдэг байдлаар задлан үнэлгээний арга хэрэгслийг оюутны эзэмших мэдлэг чадвар тус бүрээр боловсруулжээ.
- Хичээлийн хөтөлбөрийг шинэчлэх хуваарь гарган ажилласан байна.
- Хичээлийн хөтөлбөрийг жигдэлж, сайжруулан баталгаажуулсан байна.
- Сургалтын удирдлага зохион байгуулалттай холбоотой үйл ажиллагааг UNIMIS цахим системээр гүйцэтгэж түүнд хяналт тавьж ажиллаж байна. Энэ систем нь түргэн шуурхай, ил тод, хяналт хэрэгжүүлэхэд тохиромжтой ба багшийн үйл ажиллагаа, хичээл сургалт, шалгалт, цахим сургалт зэрэг үйл ажиллагааг гүйцэтгэж түүнд хяналт тавих боломжтой систем байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Анхаарах асуудал:

- Оюутнуудын сонгосон хичээлийг урьдчилан анхааруулахгүйгээр цуцалдаг тохиолдол гардаг. Ингэснээр оюутан төлөвлөсөн хугацаандаа төгсөхгүй байх, багц цагийн ачаалал нэмэгдэх зэрэг эрсдэл үүсдэг.

- Тухайн онд элссэн хөтөлбөрөөр суралцаж байх явцад сургалтын төлөвлөгөөг 2-р түвшнээс эхэлж урьдчилан мэдэгдэлгүй өөрчилсөн тохиолдол гарсан байна. Ингэснээр оюутан илүү багц цаг төлөх эрсдэл үүснэ.
- Оюутан хичээлээ сонгочоод байхад хуваарь, багшийг солих асуудал нийтлэг гардаг байна. Мөн мэргэжлийн хичээл дараалж орох ёстой байтал өөр өдөр салгаад хуваарь оруулдаг. Хичээлийн хуваарийг давхардуулж тавьснаас болж, зарим хичээлийг үзэж чадахгүй хойшлуулах асуудал гардаг.
- Хичээлийн хуваарийг оруулахдаа анги танхимын даац буюу оюутны тооноос хамааруулан багтаамжаар нь бүлэг үүсгэдэггүй.

Зөвлөмж:

- Оюутны хөтөлбөр сонголт, хичээл сонголтыг төлөвлөсний дагуу баталгаажуулах, эсвэл урьдчилан мэдэгдэх, оюутныг төлөвлөсөн хугацаандаа суралцаж төгсөх боломжоор хангахыг зөвлөж байна.
- Хичээлийн хуваарийг хийхдээ ангийн бодит ачаалалд тохируулах шаардлагатай.

4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Багш нарын 85 хувь нь эрдмийн зэрэг хамгаалсан, гадаадын өндөр хөгжилтэй оронд мэргэжил, мэргэшил дээшлүүлсэн байна.
- Олон улсын болон улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж буй судалгааны төсөлд идэвхтэй хамрагддаг.
- Олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний хурал, семинарт багш нар идэвхтэй оролцож илтгэл тавьж хэвлүүлдэг байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Анхаарах асуудал:

- Холбогдох төр, хувийн хэвшилтэй хамтын ажиллагааны хүрээнд цалинтай дадлага, хээрийн хичээл явуулах, ажлын баталгаат байрыг бий болгох шаардлагатай.

Зөвлөмж:

- Төгсөгч, ажил олгогчидтой уулзалт хийж төгсөгчдийн ур чадвар, хэрэгцээ шаардлагын талаарх судалгааг авч, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагатай эрдэм шинжилгээ, сургалтын талд хамтран ажиллах нөөц боломжийг эрэлхийлэх нь зүйтэй.

4.3 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Илрэл нотолгоо:

- Багш ажилтны цалин болон нэмэгдлийг багшийн цагийн ачаалалд тулгуурлан албан тушаалын шатлалаар цалинжуулдаг байна.
- Оюутны тоо цөөн хэдий ч магистрын оюутны тоо олон, мөн судалгаа шинжилгээний төсөл хэрэгжүүлснээр орлогыг сайн төвлөрүүлдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Анхаарах асуудал:

- Бакалаврын оюутны тоо цөөн тул сургуульд орлого бага төвлөрүүлдэг бөгөөд түүнээсээ илүү гарсан зардал гаргадаг талаар сургуулийн удирдлагаас шахалт ажиглагддаг.
- Багшийн А цагийн ачаалал их байдгаас хамаарч судалгаа, эрдэм шинжилгээний ажилд зарцуулах цаг бага, нөхцөл муутай болдог ба эрдэм шинжилгээний зардал өгдөггүй.

4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- ГУУС-аас жил бүр байгалийн ухааны оюутнуудын дунд бүтээлийн уралдаан явуулдаг.
- ГУУС-ийн ажлын төлөвлөгөөнд багш, оюутны дунд гарааны компани бойжуулах, инновацын уралдааныг явуулахаар оруулж, бэлтгэл ажлыг хийж байна.
- ШУТИС-ТУР танилцах аяллыг жил бүр тодорхой хөтөлбөрийн дагуу зохион байгуулж байна. Сошиал маркетинг, видео, шторк, контентууд болон Брэндинг хийх байдлаар олон нийтэд салбар, мэргэжил, үйл ажиллагаагаа сурталчилж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн мэдээлэл, сурталчилгаа, маркетингийн зардал харьцангуй бага.

Зөвлөмж:

- Салбар, мэргэжил сурталчлах үйл ажиллагааг салбарын яам, агентлаг, эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран улсын хэмжээнд зохион байгуулж байхыг зөвлөж байна.

4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутны гарын авлага, сургуулийн веб сайтаар дамжуулах мэдээллийг оюутан, эцэг эх, олон нийтэд хүргэж хөтөлбөрийн ил тод байдлыг хангаж байна. Мөн ШУТИС UNIMIS

системээр оюутан, багш нар харилцаж мэдээлэл солилцож, багш дотоод хяналтын үйл ажиллагааг мөн тус системээр дамжуулан гүйцэтгэж байна.

- Хөтөлбөрийн талаарх мэдээллийг олон нийт тус сургуулийн веб сайтаар дамжуулах авах боломж бүрджээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

5.1. Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- Суралцагч элсүүлэхтэй холбоотой хууль, дүрэм, журмыг мөрдлөг болгон ажиллажээ. Үүнд:
 - ✓ Дээд боловсролын тухай хуулийн 7-р зүйлийн 7.3 дахь заалт, БСШУ-ы сайдын 2018 оны 04-р сарын 06-ны өдрийн А/194 тоот “Журамд, нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тушаал,
 - ✓ БШУ-ы сайдын 2022 оны 12-р сарын 16-ны өдрийн А/540 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Оюутан элсүүлэх журам”,
 - ✓ ШУТИС-ийн захирлын 2014 оны 04-р сарын 14-ний А/64 тушаалаар батлагдсан “ШУТИС-ийн Бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 3-р бүлэг
 - ✓ Тухайн хичээлийн жилийн элсэлтийн “Босго оноо тогтоох тухай” тушаалууд
 - ✓ Тухайн хичээлийн жилд “ШУТИС-ийн бакалаврын хөтөлбөрт суралцагч элсүүлэх журам”-уудыг баримтлан оюутан элсүүлэх ажлыг зохион байгуулан ажилладаг байна.
- Элсэгчдэд тавигдах шаардлага нь
 - ✓ Бүрэн дунд боловсролтой
 - ✓ Тухайн бүлгийн ЭЕШ-ын БШУЯ-аас баталсан Үндэсний босго оноог хангасан байх
- Мөн ШУТИС-ийн захирлын 2019 оны 9-р сарын 30 өдрийн А/199 тоот тушаал “Оюутан суралцагчаар батлах тухай” Геологи хөтөлбөрт -13, ШУТИС-ийн захирлын 2020 оны 9-р сарын 15 өдрийн А/143 тоот тушаал “Оюутнаар батлах тухай” Геологи хөтөлбөрт -9, ШУТИС-ийн захирлын 2021 оны 9-р сарын 21 өдрийн А/164 тоот тушаал “Оюутнаар батлах тухай” Геологи хөтөлбөрт - 25, 2022 оны 09-р сарын 22-ны А/251 тушаал “Оюутнаар батлах тухай” Геологи хөтөлбөр – 11, АМЭХ хөтөлбөрт – 6 оюутан тус тус суралцсан ба суралцаж байна.
- Оюутнууд 2021 он дуустал геологи хөтөлбөрөөр дотроо геологи мэргэжил, АМЭХ мэргэжлээр суралцдаг байсан байна. 2019-2023 оны хүртэлх хичээлийн жилүүдэд ашигт

малтмалын эрэл, ордын хүдэржилтийн сэдэвт судалгаа хийж төгссөн 76 оюутан байгаа ба төгсөгчдийн 49 хувийг эзэлж байна.

- 2022 оны 05-р сарын 09-ний А/160 БШУ-ы сайдын тушаалаар D053209 индекс тэй АМЭХ хөтөлбөрийг баталсан.
- Геологийн хайгуул зогсонги байдалтай болсон, төрийн албанд энэ чиглэлээр ажиллагсдын цалин бага, мэдээлэл технологийн тэсрэлт болж буйтай уялдан элсэлтийн тоо эрс багассан.
- Геологи чиглэлийн хөтөлбөр эрэлттэй хөтөлбөрийн тоонд багтаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Ашигт Малтмалын Эрэл Хайгуул хөтөлбөрийн эрэлт нэмэгдэж байна.

Анхаарах асуудал:

- Сүүлийн жилүүдэд Геологи, Уул уурхайтай холбоотой гарч буй хууль, дүрэм, журамд өөрчлөлт орсон, түүнчлэн хөтөлбөрүүдийг нийлүүлэх, салгах тушаал шийдвэрүүдээс улбаалан эрхзүйн орчин өөрчлөгдөх нь геологи мэргэжлээр элсэгчдийн тоо 2018 оноос өмнөх үзүүлэлтээс буурахад хүргэсэн байна.

Зөвлөмж:

- Оролцогч талуудын өгсөн зөвлөмжийн дагуу мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжил сурталчлах, хөтөлбөрийн маркетингийг орчин цагийн суралцагчдын сэтгэлгээнд тохируулан хийхийг зөвлөж байна.

5.2. Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн хурлаар батлагдсан тухайн жилийн “Сургалтын нэгдсэн хуанли”, хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө болон сургалт, эрдэм шинжилгээ, оюутны үйл ажиллагааны чиглэлээр мөрдөгдөж буй дүрэм, журмуудыг танилцуулах үйл ажиллагааг зөвлөх багш нар хариуцан жил бүр тогтмол хийдэг ба мөн ШУТИС-ийн сургалтын систем, хөтөлбөрийн онцлогийг таниулах, суралцах нөхцөл бололцоог хангах, оюутнуудыг дэмжин ажиллах, ёс зүйтэй төлөвшсөн иргэн болгон хүмүүжүүлэх зорилготойгоор Оюутны хөгжил үйлчилгээний алба ажиллаж байна.
- Оюутнуудыг сурч боловсрох, хөгжүүлэх, судалгааны ажлын дадал суулгах, төлөвшүүлэх, багаар ажиллах чадвар суулгах зэрэгт сайн анхааран ажилласан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутнууд хүсэл сонирхлоороо нэгдсэн клубуудыг зохион байгуулж, мэдлэг, дадал, туршлага олгох зорилгоор тогтмол үйл ажиллагаа явуулж байгаа нь сайшаалтай.

Геологи-АМЭХ мэргэжлийн оюутнууд “Гео-эрдэм”, “Мета”, “MUST SEG Student Chapter” клубуудад хамрагддаг байна. Мөн оюутнуудын дунд олон талт үйл ажиллагаа явуулж байна. Үүнд: Эрдэм шинжилгээний хурлууд, салбарын байгууллагуудаас зөвлөгөө авах, танилцах, чөлөөт ярилцлага хийх, геологийн улсын олимпиадуудад амжилттай оролцож байр эзлэх, урлаг спортын тэмцээн уралдаанд оролцдог.

- АМЭХ хөтөлбөрийн 3 оюутан хугацаат цэрэг, оюутан цэргийн алба хаасан байна.

5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

Илрэл нотолгоо:

- Оюутнуудын нийгмийн идэвх, оролцоог дээшлүүлэх, тэдний авьяас чадвар, хүсэл сонирхлыг нь урамшуулан дэмжих, хөгжүүлэх зорилгоор сурлага, эрдэм шинжилгээ, урлаг спортын онцгой амжилт гаргасан шилдэг оюутнуудад урамшуулал олгох, амьдралын боломж муутай оюутнуудад дэмжлэг үзүүлж тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах зэрэг ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна. Дотоод, гадаадын 20 гаруй байгууллага ШУТИС-ийн оюутнуудад дараах тэтгэлэг, урамшуулал олгодог байна. Үүнд:
 - Ректорын нэрэмжит тэтгэлэг
 - Тоёота-ШУТИС сургалтын сангийн тэтгэлэг
 - Оюу толгой ХХК-ийн тэтгэлгүүд
 - Геотехникийн тэтгэлэгт хөтөлбөр
 - Шинэ төгсөгчийн хөтөлбөр
 - Залуусын хөгжлийн хөтөлбөр
 - Говийн Оюу-Оюутны хөтөлбөр
 - Эрдэнэс таван толгой ХК-ийн Боловсролыг дэмжих хөтөлбөр
- Мөн ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулийн оюутнуудын нийгмийн идэвх, оролцоог дээшлүүлэх, тэдний авьяас чадвар, хүсэл сонирхлыг нь урамшуулан дэмжих, хөгжүүлэх зорилгоор сурлага, эрдэм шинжилгээ, урлаг, спортын онцгой амжилт гаргасан шилдэг оюутнуудад кредитийн урамшуулал олгодог. ШУТИС-ийн Захирлын 2022 оны 04-р сарын 27-ны өдрийн А/136 тушаалаар батлагдсан “ШУТИС-ийн суралцагчдад тэтгэлэг, кредитийн урамшуулал олгох журам”-аар зохицуулагддаг.
- 2019-2022 онуудад Геологи, АМЭХ хөтөлбөрийн 20 оюутанд ШУТИС-ийн Захирлын А/172, А/18, А/06, А/14, А/152, А/59 тоот тушаалуудыг тус тус үндэслэн 0,5 кредитээс 5 кредит хүртэл урамшуулал авсан байна.
- 2017-2023 онуудад Геологи болон АМЭХ хөтөлбөрийн оюутнуудаас Оюу толгой, Рио Тинто, Мицубиши Корпорац, Судалт мана, Эрдэс таван толгой, Вэлсмон ХХК зэрэг компани, ААН-ийн шалгаруулалтыг 7 оюутан хамрагдаж 948,625 төгрөгөөс 2.000,000 төгрөгийн хооронд тэтгэлэг авсан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Оюутнуудыг ямар нэгэн тэтгэлэгт хөтөлбөр, урамшуулалд хамруулж дэмжлэг үзүүлж байгаа нь сайшаалтай.

Зөвлөмж:

- Төрөл бүрийн эх сурвалжаас тэтгэлгийн сан бий болгож, тэтгэлэгт хамрагдах оюутнуудын тоог нэмэгдүүлэх

5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Илрэл нотолгоо:

- ШУТИС-ийн захирлын 2014 оны 04-р сарын 14-ний А/64 тушаалаар батлагдсан “ШУТИС-ийн Бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг баримтлан шилжилт хөдөлгөөний асуудлыг шийдвэрлэж байна. Уг журмын 11-р бүлгийн 11.2 дахь хэсэгт заасны дагуу гадаад, дотоодын их сургуулиас ШУТИС-д, ШУТИС-аас гадаад, дотоодын их сургууль руу, ШУТИС дотроо Салбар сургууль хооронд, салбар сургууль дотроо мэргэжил хооронд шилжих эрх нь нээлттэй байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Сүүлийн жилүүдэд шилжилт хөдөлгөөн нэлээд хийгдэж гадаадад суралцахаар явж байна.

Анхаарах асуудал:

- Зарим элсэгчид өөрийн сонирхсон эрэлт ихтэй мэргэжил, хөтөлбөрт элсэж чадаагүй тохиолдолд өөр хөтөлбөрт элсэн суралцаж байгаад дамжин өнгөрөх маягаар бусад хөтөлбөрт шилжин суралцах хандлага гардаг юм байна.

5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

Илрэл нотолгоо:

- ШУТИС-ийн бакалаврын сургалтын үйл ажиллагааг зохицуулах журмын 16-р бүлэгт төгсөлтийн төсөл ажлыг амжилттай хамгаалсан, шалгалт амжилттай өгсөн оюутнуудад төгсөлтийн комиссын шийдвэрээр диплом олгох тогтоол гарснаар ШУТИС-ийн Захирлын тушаалаар бакалаврын зэргийн диплом, энгэрийн тэмдэг олгогддог.
- Төгсөлтийн баримт бичиг дэх АМЭХ хөтөлбөрийн мэдээлэл
 - Мэргэжлийн индекс: D053209
 - Мэргэжил: Ашигт малтмалын эрэл хайгуул
 - Зэрэг: Бакалавр

- Энгэрийн тэмдэг: ШУТИС

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Сурлагын үнэлгээний голч дүн 3.6 дээш бол онцлох диплом олгогддог байна.

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Илрэл нотолгоо:

- Үндсэн 7 багштай: 1 магистрын зэрэгтэй, бусад нь докторын зэрэгтэй багш нар. Докторант багш нь ойрын хугацаанд хамгаалахаар төлөвлөж байна.
- А цагийн илүү 11 орчим тогтмол жил бүр
- 1500 сая төгрөгийн төсөл сүүлийн 5 жилд хэрэгжүүлсэн.
- Mongolian Geoscientist сэтгүүлийн 4 багш редакцын зөвлөлд ажиллан Скопуст бүртгэлтэй сэтгүүл болтол хөгжүүлж чадсан байна.
- Хайгуулчин, Геологи сэтгүүлийг жилд тус бүр 1 удаа нийтэлж байна.
- ШУТИС-ийн хүний нөөцийн цогц бодлогын баримт бичиг, стратеги төлөвлөгөө болон бусад дүрэм, журмын дагуу хийгдсэн байна. ГУУС-ийн Геологи, гидрогеологийн салбарын АМЭХ хөтөлбөрийн бакалаврын сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан зорилго, зорилтоо хангахуйц онол, дадлагыг эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай мэргэжлийн туршлагатай багш нар ажиллаж байна. АМЭХ-ын хөтөлбөрийн хүрээнд докторын зэрэгтэй багш нар 90%-ийг эзэлж байна.
- ШУТИС-ийн мэргэжлийн салбар, тэнхимд ажиллах багшийн албан тушаалын ангилал, албан тушаалын тодорхойлолт, ШУТИС-ийн профессор багшид тавигдах нийтлэг шаардлага зэргийг ШУТИС-ийн захирлын 2021 оны А/234 тоот тушаалаар “Мэргэжлийн салбар, тэнхимийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ын албан тушаалын тодорхойлолтын мөрдлөг болгон ажиллаж байгаа ба ШУТИС-ийн захирлын 2022 оны А/265 тоот тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд түүнийгээ мөрдөн ажиллаж байгаа нь багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагад нийцсэн байна.
- Багшийн цагийн ачаалал тооцсон судалгаанаас харахад багш нар хэвийн ачаалалтай ажиллаж байна.

- Ажлын гүйцэтгэлийн үнэлэн урамшуулал үр дүнд тохирсон урамшуулал олгож байна. Мөн сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, инновацын чиглэлд гүйцэтгэсэн зарим ажилд олгох урамшууллыг тусгайлан шалгаруулж олгодог байна.
- АМЭХ хөтөлбөрийн багш нар төрийн одон, медаль, боловсролын болон геологийн тэргүүний ажилтан цол тэмдэг, жуух бичгээр шагнагджээ.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн багш нар оюутнууддаа их анхаарал хандуулан ажиллаж, байнга дэмжин тусалж байдаг нь сайшаалтай.

Анхаарах асуудал:

- Багш нар сэтгэл гаргаж ажиллаж байгаа ч анги танхим, тоног төхөөрөмжийн (хүчин чадалтай компьютер, микроскоп) хүртээмж муу байсаар байгаад сургуулийн удирдлага анхааран ажиллах хэрэгтэй байна.
- ШУТИС бодлогоор олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сэтгүүлийн редакцын зөвлөлд ажиллаж буй багш нар, шүүмж бичиж буй судлаачдыг дэмжиж зохих урамшууллыг төсөвлөдөг, олгодог байх, Б цагт 2 БЦ ийг бууруулахгүй редакцын зөвлөлийн гишүүн бүрд тооцож урамшуулдаг болох хэрэгтэй байна.

Зөвлөмж:

- ГУУС-ийн “Mongolian geoscientist” эрдэм шинжилгээний сэтгүүл олон улсын DOAJ (Directory of Open Access Journals), Scopus-д албан ёсны бүртгэлд хүлээн зөвшөөрөгдсөн байгаа бөгөөд үүнийг хөгжүүлэн ажиллаж байгаа редакцын зөвлөлд сургуулийн зүгээс урамшуулал олгодог байх

6.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Илрэл нотолгоо:

- ШУТИС нь 2015 онд их, дээд сургуулийн багш нарын мэргэжлийн хөгжлийг дэмжих зорилгоор Багшийн хөгжлийн төвийг байгуулан дүрмээ батлан, хэрэгжилтэд анхааран үр дүнтэй ажилласан байна.
- ШУТИС-ийн захиргаа, ҮЭХ харилцан тохиролцож “Хамтын гэрээ”-г жил бүр байгуулан, ШУТИС-ийн профессор, багш, ажилчдын хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлыг хуулиар тогтоосон баталгаанаас илүү нөхцөлөөр хангах, хөдөлмөрийн тухай хуулиар шууд зохицуулаагүй асуудлыг шийдвэрлэхэд чиглэн жил бүр төлөвлөгөө гарган хэрэгжүүлэн, ажиллаж байна. Гадаадад суралцах, мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг 2015 оны 3- дугаар сарын 15-ны өдрийн ШУТИС-ийн захирлын А/68 тоот албан тушаалыг мөрдлөг болгоно ажиллаж байна. Хөтөлбөрийн багш нар гадаад, дотоодын сургалтад сууж сертификатууд авсан байна. (Д.Энхбаяр

Боловсролын байгууллагын чанарын менежментийн тогтолцоо ISO 21001:2018 стандартыг хэрэгжүүлэх шатны 8 цагийн онол, практик хосолсон сургалтад хамрагдсан тул гэрчилгээ олгосон /2023.01.26/, Batkhishig Bayaraa Certificate of participation “Conceive, Design, Implement, and Operate (CDIO) Framework for Re-Thinking Engineering Education” as part of the Ministry of Education, Culture and Science of Mongolia-Singapore Polytechnic in Mongolia between October 20, 2015 and May 12, 2016, Batkhishig Bayaraa Successfully attended in the training of M1 Introduction M2 Implementation and completed the examination provided in conjunction with this course providing evidence of competency in the following standard ISO 9001:2015-Quality Management System) гэх мэт.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- ШУТИС-д хэрэгждэг дүрэм, журмын хүрээнд багш, ажилтны мэдлэг, боловсрол, мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэхэд эдийн засгийн зохих дэмжлэгүүд үзүүлдэг. Хөтөлбөрийн багш нарын хувьд өрөө тасалгаа хангалттай хүрч байна.

Анхаарах асуудал:

- Багш нарын А цагийн ачаалал хэвийн байдаг ч гэсэн нэг багшийн заах хичээлийн тоо олон учраас судалгаа хийх боломж хязгаарлагдмал, сургалтын баримт бичгийн зарим ажлыг үнэлдэггүй.
- Оюутан цөөн орлого олдоггүй зарлага гаргадаг салбар гэж үзэж байгаад сургуулийн удирдлагууд анхаарч ажиллах шаардлагатай.
- Сургалтын хөтөлбөрийн хөгжүүлэлт, сайжруулалтыг тасралтгүй явуулж, чанарын баталгаажуулалтыг хийдэг боловч урамшуулал байхгүй тул зохих байдлаар цагийн хөлс олгох, эсвэл В цагт тооцох боломжийг эрэлхийлэх хэрэгтэй байна.
- Сургалтын орчин бүрэн таатай биш байна. Хөтөлбөрийн багш нар энэ жил өөрсдийн хөрөнгөөр 1 анги танхим тохижуулсан байгааг харахад сургууль энэ талд анхаарал хандуулах нь зүйтэй болов уу.
- Багшийн кредитийг тооцох журамд Б-ээс А цаг руу шилжүүлэх журмын заалт хэрэгждэггүй

Зөвлөмж:

- ШУТИС-ийн удирдлагын зүгээс чанартай, чансаатай судалгаа хийж буй багш нарыг хөхүүлэн дэмжих, журамд заасны дагуу Б-ээс А руу шилжүүлж тооцдог, өөрөөр хэлбэл, дүрэм журмыг баримтлан хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Илрэл нотолгоо:

- АМЭХ хөтөлбөрийн багш, судлаачид нь дотоодын болон гадаадын их, дээд сургууль, үйлдвэр, аж ахуйн газар, бизнесийн байгууллагууд, мэргэжлийн холбоод, яамнуудтай

хамтран эрдэм шинжилгээ, онол практикийн хурал, семинар, уулзалт ярилцлагууд тогтмол зохион байгуулан ажилладаг.

- Төсөл хөтөлбөрийн хувьд: Улсын төсвийн санхүүжилттэй төсөл 11, Чиглэлийн компаниудын захиалгат гэрээт ажил 7, Олон улсын хамтарсан төсөл, хөтөлбөр 6 хэрэгжүүлэн үр дүн гаргасан байна.
- Мөн тус хөтөлбөрийн багш нар 2017-2022 онуудад дотоодын 16, салбарын 6 хурлыг зохион байгуулан ажиллахын зэрэгцээ ЭШ-ний хуралд гадаадад 13, дотоодод 18 илтгэлийг хэлэлцүүлсэн ба ЭШ өгүүлэл 21 гадаадад, 18 дотоодод хэвлүүлсэн байна. Ихэнх гадаадад хэвлүүлсэн өгүүллүүд “Journal of Asian Earth Sciences”, “Modern Approaches in Solid Earth Sciences”, “Mongolian Geoscientist” сэтгүүлүүдэд хэвлүүлсэн байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Mongolian Geoscientist ЭШ-ий сэтгүүлийг тасралтгүй эрхлэн гаргаж Скопуст бүртгэлтэй болгосон нь хөтөлбөрийн багш нарын давуу тал байна.
- Хөтөлбөрийн багш нарын ЭШ-ий үзүүлэлт сайн, олон улсын төсөл хөтөлбөр хэрэгжүүлдэг, импакт фактортай сэтгүүлд өгүүлэл хэвлэн нийтлүүлдэг, сургуульд оруулж буй хувь нэмэр оролцоо их байна.
- Хөтөлбөрийн багш нарын эрдэм шинжилгээ судалгаа, заах аргазүйн чадвар өндөр болохыг бүх оролцогч талууд хүлээн зөвшөөрч байна.

Анхаарах асуудал:

- 2050-судлаач багш байх боломжийг хангаж өгөхгүй байна.
- 1 багш 1 семестрт 5-6 хичээл заах гээд байна. Ачаалах болсон гол шалтгаан нь хүүхэд цөөн элсэж байгаатай холбоотой А цагийн ачаалал ихтэй байна.
- Эрдэм шинжилгээний багц цагийг үнэлэхдээ Б-ээс А цаг руу шилжүүлэх боломж байдаг боловч энэ журам хэрэгждэггүй.
- Сургуулиас багшид эрдэм шинжилгээний ажил хийхэд нь төдийлөн дэмжлэг үзүүлдэггүй.
- Эрдэм шинжилгээ – судалгаанд суурилсан сургууль болохоор төлөвлөсөн боловч багшийн А цагийн ачаалал их байдаг учраас судалгаа, инновац хийх боломж хязгаарлагдмал.

Зөвлөмж:

- Хэрэгжүүлж буй төслийн дүнгээс 10% татдагийг багасгаж 5% болгох, үлдсэн 5%-ийг өөрийн хөтөлбөрийн сургалтын орчин, хэрэглэгдэхүүнийг сайжруулах боломжтой тул төслийн үйлчилгээний зардлыг багасгахыг зөвлөж байна.
- Өгүүллийн чансаа, зохиогчийн оруулсан хувь нэмрээс хамаарч, багшийн гүйцэтгэлийг үнэлэхдээ ялгаатай багц цагийн үнэлгээний систем хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

- WoS бүртгэлтэй JCR индекстэй импакт фактортай эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн багш нарыг урамшуулах, нээлттэй эх сурвалж болгоход нь зохих төсвийг шийддэг болоход анхаарч ажилламаар байна.

6.4. Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Илрэл нотолгоо:

- ШУТИС багш нарыг үнэлэхдээ хэд хэдэн механизмаар үнэлдэг байна.
 - ШУТИС нь бүрэлдэхүүн сургуулиудын багш болон ажилтан нарыг ижил тэгш, үнэн бодитой үнэлэхийн тулд өөрийн үнэлгээний системийг нэвтрүүлэн батлагдсан журмыг мөрдлөг болгон ажиллаж байна.
 - Хичээлийн жилийн ажлын гүйцэтгэлийн тайлан (Урамшуулалт цалин олгоход ашигладаг)
 - Профессор, дэд профессорын цолны болзлын биелэлт
 - Оны шилдэг багшийн шалгаруулалт
- Хөндлөнгийн үнэлгээг хамтран ажилладаг хамт олны үнэлгээгээр, тодорхой үзүүлэлтийн хүрээнд 0-5 хүртэл тоогоор дүгнэн үнэлдэг юм байна.
- “Профессор, багш нарыг аттестатчилах, профессорын баг, тэнхимийн рейтинг тогтоох журам”-ыг баримтлан 3 жилд 1 удаа үнэлэн дүгнэдэг.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- ШУТИС-ийн эрдмийн хамт олныг хөгжлийн алсын хараа, эрхэм зорилгод нэгтгэж, чадварлаг манлайлагч баг болгон төлөвшүүлэх, багш бүрийн тасралтгүй сурч, хөгжих үйл ажиллагааг дэмжин, сургалт, судалгаа, нийгмийн үйлчилгээний чанарыг сайжруулах, сайн туршлагуудыг түгээн дэлгэрүүлж, урамшуулах зорилгоор “ШУТИС-ийн оны шилдэг багш” шалгаруулдаг байна.
- Хөтөлбөрийн багш нарын ажил мэргэжлийн туршлага жигд сайн байна.

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: БҮРЭН ХАНГАСАН

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

Илрэл нотолгоо:

- Хяналт шинжилгээ, дотоод аудитын албатай, сургууль, бүрэлдэхүүн сургууль, салбарын хэмжээнд тус бүр төлөвлөгөө гарган сүүлийн 3 жил тогтмол ажилладаг.
- Төгсөгчдөөс 2021-2022, 2022-2023 онд сэтгэл ханамжийн судалгаа түүхий өгөгдөл
 - Төгсөгчдөөс хөтөлбөрийн чанар, багшийн зөвлөгөө чиглүүлэг, хичээлтэй холбоотой асуудал шийдвэрлэх байдал, багшийн харьцаа хандлага, сурах, дадлага хийх боломж, сургуулийн орчны талаар судалгаа авсан байна.
 - Төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаанаас харахад зарим оюутнууд сургалтын төлөвлөгөөнд практик чадвар олгох хичээлийг нэмэх, семинарын цагийг нэмэх, гадаадын их сургуулийн хөтөлбөр рүү дөхүүлэх
- ШУТИС боловсролын байгууллагын чанарын менежментийн тогтолцоо ISO 21001:2018 стандартын шаардлагыг нэвтрүүлсэн гэрчилгээ, 2022.12.28-2024.12.28
- Баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллах тухай ГУУС-ын захирлын 2022.11.28-ны А/64 тоот тушаал: оюутан солилцоо, дипломын шүүмжлэгчийн судалгаа, оюутны зөвлөлийн гишүүд, тэтгэлэг урамшуулал олгосон оюутнууд, багш ажилтны гүйцэтгэлийн үнэлгээний тайлан, сургалтын хөтөлбөр, хичээлийн төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр, шалгалтын тест, асуулт, дипломын ажлын сэдэв, төгсөгчдийн бүртгэл, ажил олгогчдын бүртгэл, оюутны сэтгэл ханамжийн судалгаа, сургалтын орчны бүртгэл, ном сурах бичиг, гарын авлага, лабораторийн аюулгүй ажиллагааны заавар, программ хангамжийн бүртгэл, багаж төхөөрөмжийн бүртгэл зэргийг хийхээр тусгасан.
- ГУУС-ын чанарын менежментийн тогтолцооны дотоод аудитын тайлан, 2023.04.01
- 2023 оны ГГС-ын эрсдэл, боломжийн үнэлгээний дагуу эрсдлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллаж байна.
- 2022 онд чанарын үнэлгээний хөндлөнгийн судалгаа хийж тулгарч буй асуудлыг илрүүлсэн байна.
- Хичээл тус бүрээр суралцахуйн үр дүнгийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг нэгтгэсэн байна.
- Багш нарын хичээлд суух, зөвлөн туслах ажлын хуваарь гарган ажилладаг. 18 багшийн хичээлд суусан ажиглалтын хуудас гар тэмдэглэл
- Ажил олгогчдоос авах санал асуулга, түүхий өгөгдөл
- Төгсөгчдийн мэдээлэл (хувийн мэдээлэл, ажлын байрны мэдээлэл, ажил эрхлэлтийн мэдээлэл, байгууллагын мэдээлэл, ур чадварын хөгжлийн судалгаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтыг хангах удирдлага, зохион байгуулалт, дотоод чанарын баталгаажуулалтын тогтолцоо болон үйл ажиллагааны төлөвлөгөө, цаашид хэрэгжүүлэх арга замын талаар тодорхой тусгажээ.
- Хөтөлбөрийн чанарыг сайжруулах стратеги төлөвлөгөөний схем болон хөтөлбөрийн чанарын үнэлгээ, баталгаажилтын SWOT шинжилгээ хийсэн нь бодитой болжээ.

- Бакалаврын дүн, хичээлийн, хөтөлбөрийн, төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаа, ур чадварын хөгжлийн, төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, ажил олгогчдын судалгааг тодорхой хуваарийн дагуу явуулахаар төлөвлөсөн байна
- Ажил олгогч, төгсөгчдийн уулзалтаас гарсан саналыг хөтөлбөрт зохих түвшинд тусган ажилласан байна

Анхаарах асуудал:

- Суралцагчид сургалтын албаны мэргэжилтнүүдийн харилцаа хандлагад маш шүүмжлэлтэй байна.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын механизмаас гадна хөндлөнгийн баталгаажуулалтыг тогтмол хийж, хөтөлбөрийг үнэлдэг болох. Ялангуяа хичээлийн үнэлгээг сургалтын системээс хүнээс үл хараат байдлаар зохион байгуулах зайлшгүй шаардлага байна.
- Хамтын ажиллагааг өргөжүүлэх хүрээнд ажил олгогчидтой хамтран ажиллах цаашлаад хамтарсан төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эргэх холбоог бий болгох, Ажил олгогчтой хамтран, оюутны тэтгэлэгт хөтөлбөр, цалинтай дадлагын ажлыг бий болгох

7.2. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

Илрэл нотолгоо:

- Ажил олгогч байгууллагуудтай хийсэн уулзалтын тайлан, санал асуулгын түүхий өгөгдөл, дүн, Санал асуулгад ажлын байрны шаардлага, эрэлт хэрэгцээ, төгсөгчийн ур чадварын талаар багтсан байна.
- Төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгааны түүхий өгөгдөл
 - ерөнхий мэдээлэл
 - ажил эрхлэлт
 - ур чадварын судалгаа
 - ажил хайсан хугацаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- 2-3 жилийн давтамжтай ажил олгогчидтой уулзалт зохион байгуулж, төгсөгчдийн чадамж, эрэлт хэрэгцээний судалгаа хийж, сургалтын хөтөлбөрт тусгаж ажилладаг.
- Багшийн сэтгэл ханамжийн судалгааг багш нар зөрж, уламжлалт хэлбэрээр зохион байгуулдаг.

- Багш нарын сургалтын үйл ажиллагааг хөндлөнгийн багш нар хичээлийн ажиглалт хийх, сайжруулах зөвлөмж өгөх зэргээр тасралтгүй хөгжүүлэх арга хэмжээ зохион байгуулдаг.
- Төгсөгч, оюутнуудтай хийсэн ярилцлагаас дүгнэхэд геологи уул уурхайн салбарт хөрвөн ажиллах боломжтой, ажлын байрны эрэлт хэрэгцээ их байна.
- Ажил олгогчидтой хийсэн ярилцлагаас дүгнэхэд хөтөлбөрөөр төгсөгч нь ажлын байрны эрэлт хэрэгцээг зохих түвшинд хангаж, ажлын байран дээр хөгжих боломжтой байна.

Зөвлөмж:

- Санал асуулга, судалгааны үр дүнгийн учир шалтгаан, үр дагаврыг шинжлэн, цаашид авах арга хэмжээг тодорхойлж, сургалтын хөтөлбөрийн хөгжүүлэлтэд тусган ажиллаж байх
- Суралцагчдын мэдээлэл боловсруулах, тайлагнах, өөрийгөө илэрхийлэх, асуудал шийдвэрлэх, багаар ажиллах ур чадварын хөгжүүлэхүйц идэвхтэй сургалтаар, оюутан бие даан мэдлэг бүтээлгэх байдлаар сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахад анхаарах шаардлагатай.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн дэд хорооны бүрэлдэхүүнд хөтөлбөрийн багш нараас оролцдог.
- АМЭХ хөтөлбөрөөр төгссөн оюутнууд гадаад дотоодын их сургуульд магистрын сургалтад хамрагдах нь нэмэгдэж байна.
- Үндэсний магадлан итгэмжлэлд орохоор ажиллаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- ШУТИС-д боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо ISO 20001-ыг нэвтрүүлэн хэрэгжүүлж байна.

Зөвлөмж:

- Багшийн сэтгэл ханамжийн судалгааг Unimis системээс багш нараас үл хамааралтай хөндлөнгийн байдлаар зохион байгуулах нь зүйтэй.

ДУГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	3			СТЕЕР шинжилгээ, гадаад дотоодын их сургуулийн адил төстэй хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгаа, ажил олгогчидтой хийсэн уулзалт ярилцлагын үр дүнд зохих дүрэм журмын дагуу хөтөлбөрийн баримт бичгийг боловсруулдаг.
2	Сургалтын үйл ажиллагаа	3			Сургалтын үйл ажиллагаа нь ШУТИС, ГУУС-ийн эрхэм зорилгод нийцсэн, хөтөлбөрийн үр дүн, хичээлийн суралцахуйн үр дүнг уялдаа холбоотой боловсруулж, үр дүнд суурилсан сургалтын арга зүйг нэвтрүүлж хэрэгжүүлдэг.
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	2	1		Сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, ном сурах бичгийн хангалт тасралтгүй сайжирч байна. Гэхдээ сургалтын таатай орчныг бүрдүүлэх тухайлбал, орчны тохижилт, сургалтын хэрэглэгдэхүүний хүртээмжийн асуудлыг анхаарах шаардлага байсаар байна.
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	5			Хөтөлбөрийг хэрэгжүүлж сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулах зорилготой UNIMIS сургалтын системийг ашигладаг.
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	4	1		Суралцагчдын оролцоог хангаж, амжилттай суралцахад нь дэмжлэг үзүүлж, бүхий л үйл ажиллагааг хүртээмжтэй байхаар зохион байгуулахыг эрмэлздэг. Гэхдээ сургалтын албаны ажилтнуудын харилцаа хандлагыг сайжруулах оюутанд хүрсэн үйлчилгээ үзүүлэхэд анхаарч ажиллах хэрэгцээ байсаар

				байна. Түүнчлэн суралцагчийн шилжилт хөдөлгөөний судалгааг тогтмол хийж шалтгаан үр дагаврын талаар дүгнэж цаашдын үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлэх шаардлагатай.
6	Багшийн үйл ажиллагаа	4		Багш нарын ихэнх нь өндөр хөгжилтэй улсад докторын зэргээ хамгаалсан, эрдэм судлалын ажлын амжилт бүтээл арвинтай хамт олон юм. Багш нар бүгд үр дүнд суурилсан сургалтын арга зүйг хэрэгжүүлэх туршлагатай. Суралцагч, төгсөгч, ажил олгогчид ч багш нарын чадвар, идэвх зүтгэл, сургалтын үйл ажиллагааг бодитой явуулдгийг нотолж байна.
7	Чанарын үнэлгээ, баталгаажуулалт	3		АМЭХ хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай. Өөрсдийн дотоод нөөц бололцоогоор хөтөлбөрийн үнэлгээг тасралтгүй хийж хөтөлбөрийн хөгжүүлэлтийг хийж иржээ.
Дүгнэлт		БҮРЭН ХАНГАСАН		

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургуулийн Геологи, уул уурхайн сургуулийн “**Ашигт малтмалын эрэл хайгуул**” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “**ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН**” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг **Инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлтийн** чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг доктор Д.Сарангэрэл
Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....доктор Д.Одгэрэл
Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....доктор Б.Баатарцогт

ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

1. Англи хэл, хятад хэл, геологи, иргэний боловсрол, хөдөлмөр аюулгүй байдал, компьютер, мэдээллийн технологи, программ хангамжийн хичээлийн агуулгыг нэмэгдүүлэх, чанаржуулах, сонгон судлах боломж, хөтөлбөрийн уян хатан байдлыг нэмэгдүүлэхэд цаашид анхаарах нь зүйтэй. Сургалтын хөтөлбөрт мэргэжлийн хичээлийн эзлэх хувийг ихэсгэх, ерөнхий суурийн сонгон судлах хичээлийн агуулга, үйлдвэрлэлийн дадлагыг сайжруулах, чанаржуулах, үр өгөөжийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах хэрэгтэй байна.
2. Зарим сургалтын анги танхимын тохижилтыг сайжруулах, зураглалын зэрэг хичээл ордог анги танхимыг мэргэжлийн тохижилттой болгох, компьютер, сургалтын лабораторийн хүртээмж, ашиглалт, даацыг нэмэгдүүлэх, хичээлийн бус цагаар ашиглах боломжийг бий болгоход анхаарч ажиллахыг зөвлөж байна.
3. Оюутны үнэмлэх олголтыг хурдан шуурхай зохион байгуулах, номын сангийн болон бусад үйлчилгээг даруй авдаг болгох, хөтөлбөр сонголт, хичээл сонголтыг төлөвлөсний дагуу баталгаажуулах, эсвэл оюутанд нь урьдчилан мэдэгдэх, оюутныг төлөвлөсөн хугацаандаа суралцаж төгсөх боломжоор хангахыг зөвлөж байна. Хичээлийн хуваарийг хийхдээ ангийн бодит ачаалалд тохируулж, даацыг хэтрүүлэхгүй байх нь сургалтын чанарт шууд нөлөөлнө.
4. Мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжил сурталчлах, идэвхжүүлэх, хөтөлбөрийн маркетингийг орчин цагийн суралцагчдын сэтгэлгээнд тохируулан хийхийг зөвлөж байна.
5. ШУТИС-ийн удирдлагын зүгээс чанартай, чансаатай судалгаа хийж буй багш нарыг хөхүүлэн дэмжих, журамд заасны дагуу Б-ээс А руу шилжүүлж тооцдог, өөрөөр хэлбэл, дүрэм журмыг баримтлан хэрэгжүүлэх, өгүүллийн чансаа, зохиогчийн оруулсан хувь нэмрээс хамаарч, багшийн гүйцэтгэлийг үнэлэхдээ ялгаатай багц цагийн үнэлгээний систем хэрэгжүүлэхийг зөвлөж байна.
6. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын механизмаас гадна хөндлөнгийн баталгаажуулалтыг тогтмол хийж, хөтөлбөрийг үнэлдэг болох. Ялангуяа хичээлийн үнэлгээг сургалтын системээс хүнээс үл хараат байдлаар зохион байгуулах зайлшгүй шаардлага байна.

IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

№	Багшийн нэр	Албан тушаал	Эрдмийн зэрэг, цол
1	Б.Алтанзул	Дэд профессор	Доктор, дэд профессор
2	Б.Батхишиг	Чанарын менежер	Доктор, дэд профессор
3	Б.Энхжаргал	Ахлах багш	Доктор
4	С.Оюунгэрэл	Ахлах багш	Доктор
5	Д.Хашбат	Багш	Магистр

II. Оюутны нэрс

№	Оюутны код	Оюутны нэр	Түвшин	Голч оноо	Утасны дугаар
1	B231680001	М.Дашбаяр	1	Шинэ элсэгч	86852042
2	B231680004	Ш.Азжаргал	1	Шинэ элсэгч	95744595
3	B231680011	А.Баяржавхлан	1	Шинэ элсэгч	99353921
4	B231680008	Т.Тэмүжин	1	Шинэ элсэгч	95552527
5	B231680006	З.Ганбат	1	Шинэ элсэгч	80224005
6	B231680003	Ч.Билгүүн	1	Шинэ элсэгч	95507564
7	B231630001	Ч.Баярмаа	1	Шинэ элсэгч	90701701
8	B131630004	Ц.Хулан	1	Шинэ элсэгч	99785188
9	B131630011	Б.Буянхишиг	1	Шинэ элсэгч	90144389
10	B131630009	Т.Энхмаа	1	Шинэ элсэгч	99524074
11	B221680004	Ц.Алтаншагай	2	3.15	80453565
12	B221630007	М.Бадамханд	2	3.28	86135144
13	B210790005	Л.Телеуберди	3	3.35	99427092
14	B210790020	Г.Цолмонтегс	3	2.30	89229394
15	B210790001	Э.Тайванхүү	3	2.60	94211554
16	B200790001	Б.Номин	4	3.06	88108290
17	B200790002	Б.Тэргэлболд	4	3.41	80702786
18	B200790004	Х.Ууганжаргал	4	2.90	88814586
19	B200790008	Б.Билгүүн	4	2.90	86320630
20	B200790007	Ч.Анхбаяр	4	3.92	80331960
21	B200790003	Ц.Ариунболд	4	2.90	95762793
22	B190790102	Ч.Хонгорзул	5	2.82	94255281
23	B190790010	Б.Тогтохням	5	3.24	80840702
24	B180790009	Б.Бавуудорж	6	2.74	99350857
25	C.GM04D177	А.Доржготов	5+	2.02	99151793

III. Ажил олгогчдын нэрс

№	Нэрс	Байгууллага	Албан тушаал	Утасны дугаар
1	А.Дэлгэрсайхан	УУХҮЯ-ны Геологийн бодлогын газар	Хэлтсийн дарга	99173031
2	Д.Алтанхуяг	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	Ерөнхий геологич	99021244
3	М.Дамдинсүрэн	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	Геологи, хайгуулын экспедицийн дарга	99351369
4	Ц.Мөнгөншагай	Монголын үйлдвэрлэлийн геологичдын холбоо	Гүйцэтгэх захирал	99106869
5	Д.Сүхбазар	Ресурс партнерс групп ХХК	Захирал	99011787
6	Г.Цолмон	Тригтек ХХК	Захирал	99030960

7	Б.Хашгэрэл	Плюс минерал ХХК	Захирал	99110674
8	Г.Батзориг	Эрэн чулуу ХХК	Захирал	99112640
9	Өлзийбаяр	Оюутолгой ХХК	Ахлах геологич	

IV. Төгсөгчдийн нэрс

№	Нэрс	Хөтөлбөр	Төгссөн он	Байгууллага	Албан тушаал	Утасны дугаар
1	Б.Мөнхбат	2017	2017	Монгол алт ХХК	Эрлийн ахлах геологич	99287766
2	П.Баасандорж	2017	2017	Засагт хаан ХХК	Уурхайн ахлах геологич	99412843
3	П.Баатарбилэг	2018	2018	Үндэсний геологийн алба	Мэргэжилтэн	99899088
4	Г.Оргил	2018	2018	Геологийн хүрээлэн	ЭША	95796075
5	Түдэв	2020	2020	Тригтек ХХК	Ахлах геологич	88451215
6	Отгон-Үенч	2020	2020	Тригтек ХХК	Ахлах геологич	86255004
7	Ч.Нармандах	2014	2014	Солар фалкрам ХХК	Ахлах геологич	99134893
8	А.Баясгалан	2014	2014	Лак майнинг ХХК	Ахлах геологич	89019779
9	Н.Чимэдлхам	2014	2014	Эрдгео ХХК	Ахлах геологич	88024020

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ
ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН СУРГУУЛЬ

Бага тойруу 34, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14191

Утас/Факс: (976-11) 31 22 91,

Цахим шуудан: guus.info@must.edu.mn,

Цахим хуудас: www.guus.edu.mn

2023. 11. 16 № 326

танай _____-ны № _____-т

БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД

Тус сургуулийн Геологи, гидрогеологийн салбарын "Ашигт малтмалын эрэл хайгуул" бакалаврын сургалтын хөтөлбөрийн шинжээчийн багийн үнэлгээний тайланг 2023 оны 11-р сарын 13-ны өдөр цахимаар хүлээн авч танилцсан болно. Тус хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайланд бичигдсэн дүгнэлт, зөвлөмжүүдийг хүлээн зөвшөөрч хөтөлбөр хэрэгжүүлэхдээ тусган ажиллах болно.



ЗАХИРАЛ

К. ХАВАЛБОЛОТ

367770507

ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо)

[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/

ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо)

[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

Зөвлөмж /Recommendations/